



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/320

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.“а”, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 154 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст (COVID-19) цар тахлын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Шуурхай штаб, Шуурхай удирдлагын төвийн замын хөдөлгөөний камер хянаж байгаа алба хаагч, Цагдаагийн газрын сургалтын төвийг тусгаарлан ажиглах байр болгон иргэдийг хүлээн авч байгаатай холбогдуулан хүнсний материал, тусгаарлан ажиглах байрны гадна хамгаалалтад ажиллаж байгаа алба хаагчдад шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2. Аймгийн Онцгой комиссын шуурхай штаб, хяналтын постод ажиллах алба хаагчдын хоол, хүнсний материал, бичиг хэрэг, шатахууны зардалд зарцуулах 21,429,695 (хорин нэгэн сая дөрвөн зуун хорин есөн мянга зургаан зуун ерэн тав) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр)-т даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100687

Аймгийн Засаг даргын 2021 оны 26...
 дугаар сарын 19...-ны өдрийн 4/300 дүгээр
 захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Шуурхай штаб, Хяналтын цэг, шуурхай удирдлагын төв, тусгаарлах байр, шалган нэвтрүүлэх товчоонд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын хоол хүнсний материал	хүн	51 хоног		14,358,900
2	Шатахуун	тн	3,260	1500	4,890,000
3	Бичиг хэрэг, шуудан холбооны зардал				520,000
4	"Дашваанжил" ШТС	кг	84	2600	218,400
5	Хашаат сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тарны постны цахилгааны төлбөр				1,442,395
Нийт дүн					21,429,695